

ТРАНСВЕСТ МОНГОЛИА ХХК

Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 29-р хороо,
Эрчим хүчний гудамж 1, 30 тоот, Ш.Х 242 / 18031
Утас: (976)7577-9905 Факс: (976)7577-9906

Огноо 2025.01.15 № 02/30

ТӨСӨЛ ИРҮҮЛЭХ УРИЛГА

Трансвест Монголиа ХХК нь үүсгэн байгуулагдсанаасаа хойш нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчин, эрүүл мэнд, боловсрол, хөгжлийг дэмжсэн төсөл хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлж дэмжин ажилласаар байна.

2025 онд бид хүүхэд, залуучуудын эрүүл мэнд, боловсролыг дэмжих нээлттэй сонгон шалгаруулалтыг зарлаж байгаа бөгөөд хамтарч ажиллах төсөл, хөтөлбөрөө ирүүлэхийг урьж байна.

Зорилго:

Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг дэмжихэд бусад сайн дурын байгууллагын оролцоотойгоор хамтран ажиллах, нийгэмд үзүүлэх эерэг хандлагыг түгээх, идэвх санаачилгыг дээшлүүлэхэд оршино.

Төслийн хамрах хүрээ:

- Хүүхэд, өсвөр үеийнхний бие махбод болон сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих
- Сурагчдад хүртээмжтэй, эрх тэгш, суралцахад таатай орчныг бүрдүүлэх
- Хүүхэд, өсвөр үеийнхний боловсрол, мэдлэг, ур чадварыг дэмжих
- Хүүхэд, өсвөр үеийнхний сурч боловсроход эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Эмзэг бүлгийн болон тусгай хэрэгцээт хүүхдүүдийн суралцах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах

Тавигдах шаардлага:

- Сайн дурын ашгийн бус байгууллага байх
- 2 -оос доошгүй жил тогтвортой, тасралтгүй үйл ажиллагаа явуулсан байх
- Төслийг 6 сараас 1 жилийн хугацаанд хэрэгжүүлэх
- Төслийг зөвхөн Монгол улсын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх
- Төрийн бус байгууллагад тавигдах нийтлэг шаардлагыг хангасан байх

Материал ирүүлэх сүүлийн хугацаа: 2025 оны 2 сарын 25-ны өдрийн 16 цаг

Материал хүлээн авах хаяг: info@transwest.mn